



**МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

9099 оны 05 сарын 09 өдөр

Дугаар A/906

Мандалговь

Г Аймгийн төвд хийгдсэн инженерийн шугам
сүлжээний угсралтын үед гарсан авто зам,
явган хүний зам, нийтийн талбайд гарсан
эвдрэлийг засварлуулах ажлын хэсэг
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.21, 66 дугаар зүйлийн 66.1, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.1, Эрчим хүчний тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх заалтыг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь:

1. Аймгийн төвд хийгдсэн инженерийн шугам сүлжээний угсралтын үед гарсан авто зам, явган хүний зам, нийтийн талбайд гарсан эвдрэлийг засварлуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Ц.Лхагвасүрэн

(Сайнцагаан сумын Засаг даргын Тамгын газрын дарга)

Гишүүд:

Г.Ганчулуун

(Сайнцагаан сумын Нарлаг багийн Засаг дарга)

Ж.Элбэгзаяа

(Аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Газрын удирдлагын хэлтсийн Геодези, зураг зүйн асуудал хариуцсан мэргэжилтэн)

С.Энхбат

(БЗӨБ ТӨХК-ний Дундговь Цахилгаан түгээх сүлжээ салбарын ерөнхий инженер)

М.Батсүх

(Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-ийн Дундговь аймгийн газрын кабель шугамын инженер)

Б.Бямбасүрэн

(Орон нутгийн эрчим хүчний зохицуулах зөвлөлийн орон тооны гишүүн)

Д.Сэргэлэнбаатар

(Дундговь-Ус ОНӨҮГ-ын ерөнхий инженер)

Б.Батнаран

("Тэвшийнговь" ХХК-ийн дулааны хэсгийн дарга)

Э.Дашням

("Ган-Илч" ХХК-ийн ерөнхий инженер)

Б.Отгонсайхан

(Хот тохижуулах газрын ахлах инженер)

4822100811

Т.Дашравдан

(Хот тохижуулах газрын талбайн
инженер)

Нарийн бичгийн дарга: Б.Отгонсайхан

(Хот тохижуулах газрын ахлах
инженер)

2. Аймгийн төвд инженерийн шугам сүлжээний угсралтын үед гарсан авто зам,
явлган хүний зам, нийтийн талбайд гарсан эвдрэлийн судалгааг гарган, холбогдох газарт
нь хандан БНБД, стандартын дагуу засварлуулах ажлыг зохион байгуулан хийгдэж буй
ажлын талаар мэдээллийг танилцуулахыг ажлын хэсэг (Ц.Лхагвасүрэн)-т үүрэг
болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Ц.МӨНХБАТ

